



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 8 (145)

Монгол Улсын Засгийн газрын тогтоол:

- *Банкны зээлийн хугацаа хэтэрсэн өрийг барагдуулах ажлыг эрчилжүүлэх тухай*
- *Нефтийн бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах зарил арга хэтжээний тухай*
- *Мэргэжлийн зэргийн нэтэгдлийг шинэчлэн тогтоох тухай*
- *Хүнсний хангамжийн хэтжээг тогтоох тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

**Улаанбаатар хот
2000 он**



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2000 оны гуравдугаар сарын 3

№8 (145)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

98.	Зарим шүүгчийг албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 18	162
99.	Зарим шүүхийн шүүгчийг томилох тухай	Дугаар 19	162
100.	Зарим ахмад дайчныг одонгоор шагнах тухай	Дугаар 20	162
101.	Элчин сайдыг чөлөөлөх тухай	Дугаар 21	162
102.	Элчин сайдыг томилох тухай	Дугаар 22	163
103.	Жак Леграныг "Найрамдал" медалиар шагнах тухай	Дугаар 23	163

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

104.	Банкны зээлийн хугацаа хэтэрсэн өрийг барагдуулах ажлыг эрчимжүүлэх тухай	Дугаар 203	163
105.	Нефтийн бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах зарим арга хэмжээний тухай	Дугаар 207	164
106.	Дүрэм батлах тухай	Дугаар 209	164
107.	Журам батлах тухай	Дугаар 211	169
108.	Мэргэжлийн зэргийн нэмэгдлийг шинэчлэн тогтоох тухай	Дугаар 213	170
109.	Хүнсний хангамжийн хэмжээг тогтоох тухай	Дугаар 214	170

Гурав. ЯАМ, АГЕНТЛАГИЙН АКТ

110.	Журам батлах тухай (Сангийн сайд, хууль зүйн сайд, Дэд бүтцийн хөгжлийн сайдын 1999-12-31-ний тушаал)	Дугаар 232/297/351	170
111.	Шалгуур үзүүлэлт батлах тухай (Гэгээрлийн сайдын 1999-12-17-ны тушаал)	Дугаар 275	172
112.	Журам батлах тухай (Дэд бүтцийн хөгжлийн сайдын 1999-11-30-ны тушаал)	Дугаар 313	179
113.	Дэд хөтөлбөр батлах тухай (Цагдаагийн ерөнхий газрын даргын 1999-6-30-ны тушаал)	Дугаар 443	183
114.	Журам батлах тухай (Цагдаагийн ерөнхий газрын даргын 1999-10-12-ны тушаал)	Дугаар 647	185
115.	Журам батлах тухай (Гаалийн ерөнхий газрын даргын 1999-12-22-ны тушаал)	Дугаар 505	186



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 02 дугаар сарын 04-ний өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Зарлиг болгох нь:

Өөр шүүхэд шилжин ажиллах болсонтой холбогдуулан Оросоогийн Зандрааг Нийслэлийн Чингэлтэй дүүргийн шүүхийн шүүгчийн, Базарсүрэнгийн Сарантуяаг Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн шүүхийн шүүгчийн, Ванчиндоогийн Жавхланг Баянхонгор аймгийн шүүхийн шүүгчийн, Содномтүнрэвийн Будыг Сүхбаатар аймгийн шүүхийн шүүгчийн, Цогнямын

Зарим шүүгчийг албан тушаалаас чөлөөлөх тухай

Балжиннямыг Увс аймгийн шүүхийн шүүгчийн, Хайдавын Цэсмааг Дорнод аймгийн хэсгийн ардын шүүхийн шүүгчийн, гадаадад аспирантурт суралцах болсонтой нь холбогдуулан Лхайжавын Сарангэрэлийг Нийслэлийн Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 02 дугаар сарын 04-ний өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 2, Шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсгийг баримтлан Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Зарлиг болгох нь:

Оросоогийн Зандраа, Базарсүрэнгийн Сарантуяа нарыг Нийслэлийн шүүхийн шүүгчийн, Агвааны Сугарсүрэнг Дундговь аймаг дахь сум дундын шүүхийн ерөнхий шүүгчийн, Ванчиндоогийн Жавхланг Нийслэлийн Сүхбаатар

Зарим шүүхийн шүүгчийг томилох тухай

дүүргийн шүүхийн шүүгчийн, Содномтүнрэвийн Будыг Нийслэлийн Чингэлтэй дүүргийн шүүхийн шүүгчийн, Цогнямын Балжиннямыг Төв аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Хайдавын Цэсмааг Дорнод аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 02 дугаар сарын 04-ний өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

1939 оны Халх голын байлдаан, 1945 оны чөлөөлөх дайнд биечлэн оролцож, эх орныхоо тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хамгаалах үйл хэрэгт оруулсан гавьяаг нь үнэлж Нийслэлийн Хан-Уул Дүүргийн 6-р хорооны иргэн, ахмад дайчин Ламжавын Лхунрэвийг Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор, Говь-Алтай аймгийн

Зарим ахмад дайчныг одонгоор шагнах тухай

Чандмань сумын иргэн, ахмад дайчин Амаржаргалын Гунгаа, Ишжанцангийн Равдан, Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 9 дүгээр хорооны иргэн Хоролхүүгийн Чойжилсүрэн нарыг Цэргийн гавьяаны одонгоор тус тус шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 02 дугаар сарын 14-ний өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

Монгол Улсын Үндсэн Хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, "Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль"-ийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ болгох нь:

Элчин сайдыг чөлөөлөх тухай

Бадам-Очирын Должинцэрэнг Монгол Улсаас Бүгд Найрамдах Филиппин Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

Өөр ажилд шилжсэнтэй нь холбогдуулан



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 02 дугаар сарын 14-ний өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

Элчин сайдыг темилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, "Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуул"-ийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг тус тус баримтлан Зарлиг болгох нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Филиппин Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Агваандоржийн Цолмонг тохоон томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 02 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

Жак Леграныг "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол судлалыг хөгжүүлэх, Монгол Улсыг Франц улсад сурталчлан таниулахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Бүгд Найрамдах Франц Улсын иргэн, монголч

эрдэмтэн Жак Леграныг "Найрамдал" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 12 дугаар сарын 1-ний өдөр

Дугаар 203

Улаанбаатар хот

Банкны зээлийн хугацаа хэтэрсэн өрийг барагдуулах ажлыг эрчимжүүлэх тухай

Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1, 3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

ажиллагааны хэвийн нөхцөлийг хангах, техник хангамжийг сайжруулах, боловсон хүчнийг давтан бэлтгэх, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх арга хэмжээнд зарцуулж байхыг Сангийн сайд Я.Очирсүх, Хууль зүйн сайд Д.Ганболд нарт зөвшөөрсүгэй.

1.Банкны зээлийн хугацаа хэтэрсэн өрийг барагдуулах ажлыг эрчимжүүлэх, нэгтгэн зохицуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Монгол банктai зөвшилцсөний үндсэн дээр хамтран байгуулж ажиллахыг Хууль зүйн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Д.Ганболдод үүрэг болгосугай.

3.Банкны зээлийн хугацаа хэтэрсэн өрийг барагдуулах албаны үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, цаашид хэрхэн өөрчлөн зохион байгуулах тухай саналаа энэ оны 12 дугаар сарын 15-ны дотор танилцуулахыг Сангийн сайд Я.Очирсүх, Хууль зүйн сайд Д.Ганболд нарт даалгасугай.

2.Монгол банктai зөвшилцөн, арилжааны банктai гэрээ байгуулсны үндсэн дээр банкны зээлийн хугацаа хэтэрсэн өрийг барагдуулах арга хэмжээний хүрээнд төлөгдсөн хөрөнгийн 10 хүртэлх хувийг Монгол банк дахь тусгай дансанд төвлөрүүлж, шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын үйл

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Р.АМАРЖАРГАЛ

САНГИЙН САЙД БӨГӨӨД ХУУЛЬ ЗҮЙН
САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Я.ОЧИРСҮХ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 12 дугаар сарын 8-ны өдөр

Дугаар 207

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын нөөцийн нефтийн бүтээгдэхүүнийг татан авах, шинэчлэх, хадгалах үйл ажиллагаанд 1991-1998 онд гарсан зардлын санхүүжилтэд зориулж улсын төсвөөс "НИК" хувьцаат компанид олгох өрийг тус компаниас Гаалийн ерөнхий газарт импортын татвар болон тусламжийн санд төвлөрүүлэх төлбөрөөс харилцан суутгал хийх замаар барагдуулахыг Сангийн сайд Я.Очирсүх, Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч.Содномцэрэн нарт даалгасгай.

2. БНХАУ-аас буцалтгүй тусламжаар нийлүүлэх 25 сая юанийн үнэ бүхий нефтийн бүтээгдэхүүнийг "НИК" хувьцаат компаниар

Нефтийн бүтээгдэхүүний хангамжийг Сайжруулах зарим арга хэмжээний тухай

дамжуулан борлуулж, орлогыг тухайн бараа нийлүүлэгдсэнээс хойш гэрээний дагуу 6 сарын дотор тусгай санд төвлөрүүлэн, Замын-үүд өртөөнд шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж барихад шаардагдах монголын талын зардлын санхүүжилтэд зарцуулахыг Сангийн сайд Я.Очирсүх, Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч.Содномцэрэн, Дэд бүтцийн хөгжлийн сайд Г.Батхүү нарт зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Р.АМАРЖАРГАЛ

САНГИЙН САЙД

Я.ОЧИРСҮХ

ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ҮЙЛДВЭРИЙН САЙД

Ч.СОДНОМЦЭРЭН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 12 дугаар сарын 8-ны өдөр

Дугаар 209

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

"Галын аюулгүй байдлын тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Гал түймэртэй тэмцэх газрын дүрэм"-ийг 1 дүгээр хавсралтын, "Гал түймрийн улсын хяналтын дүрэм"-ийг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан

"Улсын гал түймрийн хяналтын тухай дүрмийг батлах тухай" БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1986 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 257 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Р.АМАРЖАРГАЛ

САНГИЙН САЙД БӨГӨӨД ХУУЛЬ ЗҮЙН
САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Я.ОЧИРСҮХ

Засгийн газрын 1999 оны 209 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

ГАЛ ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Гал түймэртэй тэмцэх газрын зорилго нь Галын аюулгүй байдлын болон Ой хээрийг түймрээс хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, гал түймэртэй тэмцэх улсын нэгдсэн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхэд оршино.

2. Гал түймэртэй тэмцэх газар нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг бөгөөд үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомж болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

3. Гал түймэртэй тэмцэх газар нь аймаг, нийслэлийн Гал түймэртэй тэмцэх хэлтэс, албыг байгуулж, үйл ажиллагааг нь мэргэжил, арга зүй, хяналт шалгалт, зохион байгуулалтын нэгдсэн удирдлагаар хангах мэргэжсэн төв байгууллага бөгөөд Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд ажиллана.

4. Гал түймэртэй тэмцэх газрын удирдлагын орон тоо, албан тушаалын зэрэглэл, цалингийн жишгийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.



5. Гал түймэртэй тэмцэх газар нь тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Гал түймэртэй тэмцэх газрын зохион байгуулалтын бүтэц

6. Гал түймэртэй тэмцэх газар нь захиргаа удирдлагын, гал түймэр унтраах, шинжилгээ судалгааны болон бусад нэгжтэй байна. Гал түймэр унтраах алба нь хот суурин болон ой, хээрийн гэсэн дэд нэгжтэй байж болно.

7. Гал түймэртэй тэмцэх газрын дарга /цаашид газрын дарга/ гэнэ/ нь гал түймрийн улсын хяналтын ерөнхий байцаагч байх бөгөөд түүнийг "Галын аюулгүй байдлын тухай" хуулийн 4.6 дахь хэсэгт заасан журмын дагуу томилж, чөлөөлнө.

8. Гал түймэртэй тэмцэх газрын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг шийдвэрлэхэд даргад зөвлөх эрхтэй газрын даргын зөвлөл ажиллана. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг газрын даргын тушаалаар батална.

9. Газрын дарга нь аймаг, нийслэлийн хэлтэс, албаны даргыг аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр, гал түймэртэй тэмцэх байгууллагын бусад офицер, албан хаагчдыг шууд томилж, чөлөөлнө.

10. Газрын дарга хууль тогтоомжид нийцүүлэн эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал шийдвэр гаргаж биелэлтийг хангуулна.

Гурав. Гал түймэртэй тэмцэх газрын үүрэг, эрх

11. Гал түймэртэй тэмцэх газар нь дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

а/ Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;

б/ Гал түймэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар аймаг, нийслэлийн Гал түймэртэй тэмцэх хэлтэс, албадыг мэргэжлийн нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, чиглүүлэх;

в/ Гал түймрийн улсын хяналтыг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулж биелэлтэд хяналт тавих;

г/ Гал түймэртэй тэмцэх газар, хэлтэс, албадын хоорондын ажлын уялдааг зохицуулан хэтийн хөгжлийн төлөвийг тодорхойлох, байршлыг холбогдох байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран боловсруулж хэрэгжүүлэх;

д/ Гал түймэртэй тэмцэх техник, тоног төхөөрөмж, зэвсэглэмж, сэлбэг хэрэгслийг гадаад, дотоод зах зээлээс захиалж, хангалт хийх;

е/ Гал түймэртэй тэмцэх байгууллагын бие бүрэлдэхүүнийг дүрэмт болон хөдөлмөр хамгааллын хувцсаар хангах;

ж/ Гал түймэртэй тэмцэх байгууллагад ажиллах мэргэжлийн офицер боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах ажлыг зохион байгуулах;

з/ Гал түймрийн судалгаа, тоо бүртгэлийг хөтөлж гал түймрийн үүсэлт, шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн цогцолбор арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх;

и/ Мэдээллийн хэрэгслийг ашиглаж гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх арга, галын аюулгүй байдлыг хангах арга хэмжээний талаар тайлбарлан таниулж сурталчлах;

й/ Барилга байгууламжийн хийц, бүтэц, материалын гал тэсвэршилтийг судлах, барилга объектыг ашиглалтад авах зөвлөл, комиссын бүрэлдэхүүнд оролцож бүрэн эрхийнхээ асуудлаар санал дүгнэлт гаргах;

л/ Гал түймэртэй тэмцэх байгууллагын хэмжээнд улсын төвлөрсөн төсвөөр барих барилга байгууламжийг бариулах, ашиглалтад хүлээн авах;

м/ Гал түймэртэй тэмцэх байгууллагын үйл ажиллагаатай холбогдуулан байгууллага, иргэдээс гаргасан санал, өргөдөл, гомдлыг зохих журмын дагуу хянан шийдвэрлэх;

н/ Галын аюулгүйн дүрэм, техникийн норматив, стандартын төсөл боловсруулж холбогдох байгууллагатай хамтран батлах, гал түймэртэй тэмцэх талаар мэргэжлийн зөвлөмж, санамж, товхимол гаргах;

о/ Галын техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ эрхлэх.

12. Гал түймэртэй тэмцэх газар нь дор дурдсан эрх эдэлнэ:

а/ Гал унтраах анги, салбар, хэсгийг байгуулах, зэрэглэл, орон тоо, нормативыг өөрчлөх, татан буулгах асуудлыг аймаг, нийслэлийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх;

б/ Галын аюулгүй байдлын болон Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай хууль тогтоомж, шийдвэрийн биелэлтийг шалгаж илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

в/байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан, иргэдэд галын хэргийн анхан шатны мэдлэг олгох, гал унтраах тоног төхөөрөмж, анхан шатны багаж хэрэгслийг ашиглах талаар мэргэжлийн туслалцаа үзүүлэх, галын аюулаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг хийх;

г/гал түймэртэй тэмцэх асуудлаар олон улсын болон гадаад улсын адил мэргэжлийн байгууллагатай харилцан ажиллах.

13. Гал түймэртэй тэмцэх газар нь гал түймэртэй тэмцэх байгууллагын нийт алба хаагчийн үйл ажиллагаанд дотоодын хяналт тавьж хууль тогтоомж зөрчих явдлаас урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ

авна.

14. Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн тавьсан нотломж, шаардлага захиргааны арга хэмжээний талаар гарсан гомдлыг шалгаж шийдвэрлэнэ.

15. Гал түймэртэй тэмцэх газрын бие бүрэлдэхүүн Монгол Улсын Ерөнхийлөгчийн баталсан цол, ялгах тэмдэг, дүрэмт хувцас хэрэглэнэ.

16. Энэ дүрмээр зохицуулагдаагүй бусад асуудлыг гал түймэртэй тэмцэх байгууллагын дотоод албаны дүрмээр зохицуулна. Дүрмийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Засгийн газрын 1999 оны 209 дүгээр тогтоолын 2 дугаар хэсгээс

ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Гал түймрийн улсын хяналтын зорилт нь ой хээрийг болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмч хөрөнгийг гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, "Галын аюулгүй байдлын" болон "Ой, хээрийг гал түймрээс хамгаалах тухай" хууль, тэдгээрийг үндэслэн эрх бүхий байгууллагаас тогтоосон галын аюулгүй байдлын талаархи дүрэм, журам, стандарт, бусад техникийн нормативын биелэлтийг хангуулахад оршино.

2. Гал түймрийн улсын хяналтыг гал түймрийн улсын хяналтын байцаагч /цаашид "байцаагч" гэнэ/ хэрэгжүүлнэ.

3. Гал түймрийн улсын хяналтын ерөнхий байцаагч нь ахлах байцаагч, байцаагч нарыг томилж, чөлөөлж, гал түймрийн улсын хяналтын байцаагчийн эрх олгоно.

4. Байцаагч нь үйл ажиллагаандаа Монгол Улсын холбогдох хууль тогтоомж болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

5. Байцаагч нь хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн загварыг нь баталсан үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэг, заавал биелүүлэх албан шаардлага, дүгнэлт, гал түймэр гарсан тухай нотломж, тодорхой үйл ажиллагааг түр буюу бүрмөсөн зогсоох тухай

тогтоолын хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

6. Гал түймэртэй тэмцэх газар нь байцаагчдыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж үйл ажиллагаанд нь хяналт тавина.

7. Байцаагч энэ дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй болон хууль тогтоомж зөрчсөн бол холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих хариуцлага хүлээнэ.

Хоёр. Гал түймрийн улсын хяналт явуулах чиглэл

8. Гал түймрийн улсын хяналтыг гал түймэртэй тэмцэх байгууллага дараахь чиглэлээр хэрэгжүүлнэ:

а/галын аюулгүй байдлын тухай болон Ой хээрийг түймрээс хамгаалах тухай хууль, галын аюулгүй байдлын шаардлагыг тодорхойлсон стандарт, дүрэм, журам болон бусад техникийн нормативын хэрэгжилтэд хяналт тавих;

б/гал түймэртэй тэмцэх, галын аюулаас урьдчилан сэргийлэх талаар зохион хэрэгжүүлэх ажлын хөрөнгө, төсвийн төлөвлөлт, гал түймрийг илрүүлэх, унтраах автомат тоног төхөөрөмж, гал унтраах анхан шатны багаж



зэвсгийн нөхөн хангалт, ашиглалт, хадгалалтын байдалд хяналт тавих;

в/хот, суурин газар байгуулах, барилга байгууламж барих, өргөтгөх, засварлах зураг төсөлд галын аюулгүйн техникийн нөхцөлийн мөрдөлтийг хянаж дүгнэлт гаргах болон барилга байгууламж хүлээлцэх комиссын бүрэлдэхүүнд оролцох;

г/гал түймрийн аюулгүй байдлын талаар гал түймэртэй тэмцэх байгууллага, эрх бүхий албан тушаалтны хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан шийдвэрийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын албан тушаалтан хэрхэн биелүүлж байгаа байдалд хяналт тавьж, үнэлгээ өгөх;

д/ой, хээр болон хот суурин газрын объектыг гал түймрийн аюулаас хамгаалах ажлыг зохион байгуулах асуудлыг шийдвэрлэхэд оролцох;

е/гал түймрийн судалгаа, тоо бүртгэлийг хөтөлж, гал түймэр гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох, түүнийг арилгахад чиглэсэн арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх, хуульд заасан журмын дагуу хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулах;

ж/иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад объектын болон ой хээрийн түймэр гарсан үед шуурхай мэдээлэх, унтраах бэлтгэл, гал түймрээс хүний амь, эд материал, байгалийн баялгийг аврах, учирч болох хохирлыг багасгахад чиглэсэн арга хэмжээг урьдчилан авсан эсэхэд хяналт шалгалт хийж, хэрэгжилтэд хяналт тавих.

Гурав. Байцаагчийн үүрэг, эрх

9. Байцаагч нь дор дурдсан үүрэг хүлээнэ:

а/энэ дүрмийн 8 дахь хэсэгт заасан чиглэлийг хэрэгжүүлж ажиллах;

б/өмчийн хэлбэр харгалзахгүйгээр байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн орон байрны галын аюулгүйн байдлыг шалган, илрүүлсэн зөрчлийг таслан зогсоох, арилгуулах арга хэмжээ авах;

в/хийсэн хяналт-шалгалт, гаргасан дүгнэлт, бичсэн нотломж, танилцуулга, албан шаардлага, тоо баримтын үндэслэл, нотолгооны үнэн зөвийг бүрэн хариуцах.

10. Байцаагч нь дор дурдсан эрх эдэлнэ:

а/хяналт шалгалт хийх иргэдийн орон сууц болон объектод саадгүй нэвтрэн орох;

б/холбогдох байгууллагатай нь тохиролцсоны үндсэн дээр хот суурин газар, байгууллага, аж ахуйн нэгжийн галын аюулгүй байдлыг хангах арга хэмжээг боловсруулах, галын аюулгүй байдлын техникийн дүгнэлт гаргах зэрэгт улсын хяналтын байгууллагын инженер-техникийн ажилтан, эрдэм шинжилгээ, зураг төслийн байгууллагын мэргэжилтэнг татан оролцуулах;

в/аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаас гал түймрийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон баримт бичиг, мэдээ, материалыг шаардан гаргуулж авах;

г/гал түймрийн тухай мэдээлэх, ой хээрийн болон объектын гал түймрийг унтраах, хойшлуулшгүй арга хэмжээ авахын тулд өмчийн хэлбэр харгалзахгүйгээр холбооны хэрэгслийг үнэ төлбөргүй, дараалал харгалзахгүй түр ашиглах;

д/гал гарах бодит аюул бүрдсэн, гал гарсан тохиолдолд хүний амь, эд хөрөнгийг авран хамгаалах боломжгүй гэж үзвэл иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл ашиглахыг хэсэгчлэн буюу бүрмөсөн хориглох, тэдгээрээс тодорхой ажил, үйлчилгээ явуулахыг түр буюу бүрмөсөн зогсоох;



е/гал түймэр унтраах зорилгоор ашигладаг усны шугам сүлжээ, худаг, усан санг байнгын ажиллагаатай байлгахыг холбогдох байгууллагаас шаардах;

ж/хот суурин газар, ой хээрт гарсан гал түймрийг унтраах, түүний үр дагаврыг арилгахтай холбогдсон хойшлуулшгүй ажилд дипломат албаны болон тусгай үйлчилгээнийхээс бусад автомашин, механизм, ердийн тээврийн хэрэгслийг дайчлах;

з/галын аюулгүйн дүрэм заавар зөрчигсөд, гал түймэр тавьсан гэм буруутай этгээдэд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх;

и/хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан, нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулах;

к/гал түймрийн хэрэг, зөрчлийг шалгах, галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтаар явах үед хот суурингийн доторхи нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 12 дугаар сарын 8-ны өдөр

Дугаар 211

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 34 дүгээр зүйл, Дотоодын цэргийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2, Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Цагдаа, шүүхийн шийдвэр биелүүлэх, гал түймэртэй тэмцэх байгууллагын болон дотоодын цэргийн алба хаагчдад төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ыг хавсралтын ёсоор баталж, 2000 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2.Хилийн цэрэгт алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журмыг боловсруулж 1999 оны 12 дугаар сард багтаан Засгийн газарт оруулж

Дөрөв.Бусад зүйл

11.Байцаагч нь хууль тогтоомж, холбогдох дүрэм, журам зөрчсөн, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй гэм буруутай этгээдэд "Галын аюулгүй байдлын тухай", "Ой хээрийг түймрээс хамгаалах тухай", "Захиргааны хариуцлагын тухай" хууль болон бусад хууль тогтоомжид заасан шийтгэл ногдуулна.

12.Зөрчил гаргасан этгээд түүнд ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийг тогтоосон хугацаанд нь улсын төсвийн орлогод оруулна.

13.Шалгагдсан байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэд хяналт шалгалтын явцад хууль тогтоомж зөрчигдсөн, байцаагчийн гаргасан шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо хяналт шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид, эсвэл Ерөнхий байцаагчид шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш 10 хоногт багтаан гаргана. Гомдлыг хүлээн авсан байгууллагын эрх баригч түүнийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан хянан шийдвэрлэнэ. Хэрэв энэ шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно.

шийдвэрлүүлэхийг Батлан хамгаалахын сайд Ш.Түвэндоржид даалгасугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Нийгмийг аюулаас хамгаалах яамны генерал, офицер, улирагчдын цалингийн схем, удаан жилийн нэмэгдлийн тухай" БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1979 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 190 дүгээр тогтоолыг 2000 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Р.АМАРЖАРГАЛ

САНГИЙН САЙД БӨГӨӨД ХУУЛЬ ЗҮЙН
САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Я.ОЧИРСҮХ



Засгийн газрын 1999 оны 211 дүгээр
тогтоолын хавсралт

ЦАГДАА ШҮҮХИЙН ШИЙДВЭР БИЕЛҮҮЛЭХ, ГАЛ ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ БАЙГУУЛЛАГЫН БОЛОН ДОТООДЫН ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДАД ТӨРИЙН ТУСГАЙ АЛБА ХААСАН ХУГАЦААНЫ НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ

1.Цагдаа, шүүхийн шийдвэр биелүүлэх, тусгай алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн
гал түймэртэй тэмцэх байгууллагын болон алба хаагчийн албан тушаалын сарын үндсэн
дотоодын цэргийн офицер, улирагсдад төрийн цалингаас дор дурдсан хувиар бодож олгоно:

Төрийн алба хаасан хугацаа (жилээр)	Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийн хэмжээ (хувиар)
5-7	5
8-10	8
11-14	12
15-19	15
20-24	20
25 ба түүнээс дээш	27

2.Төрийн албанд ажилласан хугацааг тогтоох үндсэн баримт нь албан хаагчийн хувийн хэрэг, нийгмийн даатгалын болон хөдөлмөрийн дэвтэр байна.

б/төрийн тусгай албанд ажиллах хугацаандаа дотоод, гадаадын академи, дээд, тусгай сургууль, мэргэжил дээшлүүлэх дамжаа, адъюнктур, магистрантур, докторантурт суралцсан;

3.Төрийн тусгай алба хаасан хугацаанд дараахь хугацааг оруулан тооцно:

а/төрийн тусгай албанд ажилласан;

в/төрийн албанд ажиллах хугацаандаа жирэмсний, амаржсаны болон өвчний учир чөлөөтэй байсан.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 12 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 213

Улаанбаатар хот

Мэргэжлийн зэргийн нэмэгдлийг шинэчлэн тогтоох тухай

Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

мөрдүүлсүгэй;

1.Зэвсэгт хүчин, хилийн цэрэг, иргэний хамгаалалтын офицер, ахлагч, гэрээт цэргийн албан хаагчийн цэргийн мэргэжлийн зэргийн нэмэгдлийг үндсэн цалингийн дор дурдсан хувиар тогтоосугай:

б/офицер, ахлагч, гэрээт цэргийн албан хаагчид мэргэжлийн зэргийн нэмэгдэл олгоход шаардагдах зардлыг холбогдох агентлагуудынхаа 2000 оны цалингийн санд багтаан гаргаж, цаашид тэдгээрийн жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлж байсугай.

- а/1 зэрэгт 15 хувь;
- б/П зэрэгт 10 хувь;
- в/Ш зэрэгт 5 хувь.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Батлан хамгаалах хүчийг бэхжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1979 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 13 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

2.Батлан хамгаалахын сайд Ш.Түвдэндоржид даалгах нь:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Р.АМАРЖАРГАЛ

а/офицер, ахлагч, гэрээт цэргийн албан хаагчид мэргэжлийн зэрэг олгох журмыг 2000 оны I улиралд багтаан шинэчлэн баталж

БАТЛАН ХАМГААЛАХЫН
САЙД

Ш.ТҮВДЭНДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 12 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 214

Улаанбаатар хот

Хүнсний хангамжийн хэмжээг тогтоох тухай

Хилийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

гаргах арга хэмжээ авахыг Батлан хамгаалахын сайд Ш.Түвдэндоржид, уг зардлын мөн оны сүүлийн хагаст ногдох хэсгийг төвлөрсөн төсвийн зохицуулалтаар шийдвэрлэж өгөхийг Сангийн сайд Я.Очирсүхэд тус тус даалгасугай.

1. Хилийн суман, харуулд алба хааж байгаа офицер, ахлагч нарт олгох хоногийн хүнсний хангамжийн хэмжээг хавсралтын ёсоор баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Р.АМАРЖАРГАЛ

2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлээр батлагдсан хүнсний хангамжид шаардагдах зардлын 2000 оны эхний хагаст ногдох хэсгийг Хилийн цэргийг удирдах газрын төсөвт багтаан

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД

Ш.ТҮВДЭНДОРЖ

САНГИЙН САЙД

Я.ОЧИРСҮХ

Засгийн газрын 1999 оны 214 дүгээр тогтоолын хавсралт

ХИЛИЙН СУМАН, ХАРУУЛД АЛБА ХААЖ БАЙГАА ОФИЦЕР, АХЛАГЧ НАРЫН ХОНОГИЙН ХҮНСНИЙ ХАНГАМЖИЙН ХЭМЖЭЭ

№	Хүнсний бүтээгдэхүүний нэр	Хэмжээ (грамм)
1.	Мах	550
2.	Гурил	550
3.	Цагаан будаа	100
4.	Цөцгийн тос	40
5.	Элсэн чихэр	60
6.	Гоймон	40

Тайлбар: 1. Энэ хавсралтаар баталсан хүнсний бүтээгдэхүүнийг алгасч болон орлуулан хэрэглэхийг хориглоно.

2. Энэ хавсралтад заагдаагүй боловч уг нормд ордог хүнсний бүтээгдэхүүнийг зохих журмын дагуу тогтоосон илчлэгт нь багтаан орлуулан хэрэглэж болно.

САНГИЙН САЙД, ХУУЛЬ ЗҮЙН САЙД, ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН ТУШААЛ

1999 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

Дугаар 232/297/351

Улаанбаатар хот

Журам батлах тухай

"Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 37 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 1995 оны 38 дугаар тогтоолыг үндэслэн тушаах нь:

журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

САНГИЙН САЙД Я.ОЧИРСҮХ

ХУУЛЬ ЗҮЙН САЙД ДАШ, ГАНБОЛД

ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН САЙД Г. БАТХҮҮ

"Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн хөрөнгийг үнэлэх мэргэжлийн байгууллагыг сонгон шалгаруулах



Сангийн сайд, Хууль зүйн сайд, Дэд бүтцийн хөгжлийн сайдын 232/297/351 тоот тушаалын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТой АЖ АХУЙН НЭГЖИЙН ХӨРӨНГИЙГ ҮНЭЛЭХ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Хөрөнгийн үнэлгээний зах зээлд шударга өрсөлдөөнийг хөгжүүлэх зорилгоор төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн хөрөнгийг үнэлэх үнэлгээний мэргэжлийн байгууллагыг сонгон шалгаруулахтай холбогдсон үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Сонгон шалгаруулах ажлын хэсэг, түүний үүрэг, эрх

2.1 Хөрөнгийн үнэлгээний ажлыг үнэн зөв, бодитой, шударга гүйцэтгүүлэх зарчмыг баримтлан үнэлгээний компаниудыг төрийн өмчийн эд хөрөнгийг үнэлэх ажилд чөлөөтэй оролцуулах үүднээс тэднийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулж, Гүйцэтгэгч /үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгж-ийг шалгаруулна.

2.2 Хувьчлагдах төрийн өмчит аж ахуйн нэгжийн хөрөнгийг үнэлэх ажлыг гүйцэтгэх үнэлгээний мэргэжлийн байгууллагуудыг сонгон шалгаруулах орон тооны бус ажлын хэсэг /Сангийн сайд, Хууль зүйн сайдын 1999 оны 38/36 тоот тушаалд заасны дагуу/-ийг 5-7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулна. Ажлын хэсэг нь нарийн бичгийн даргатай байна.

2.3 Сонгон шалгаруулах ажлын хэсэг нь үнэлэгдэх аж ахуйн нэгж /цаашид захиалагч гэнэ/-ийн техник, эдийн засгийн үзүүлэлтийг судлах, гүйцэтгэгчийг шалгаруулахтай холбогдсон баримт материалыг нэгтгэж нууцлах, Гүйцэтгэгч, Захиалагчийн хооронд итгэлцлийг бий болгох ажлыг зохион байгуулна.

2.4 Сонгон шалгаруулах ажлын хэсэг нь шалгарсан Гүйцэтгэгчийн ажлын явц, гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг хянаж талуудад албан шаардлага тавих, хэрэгжилтийн талаар дүгнэлт гаргах эрхтэй.

2.5 Сонгон шалгаруулах ажлын хэсэг нь сонгон шалгаруулахтай холбоотой асуудлаар гүйцэтгэгч болон түүний эрх ашгийг төлөөлж байгаа аливаа байгууллага, хүмүүсийн нөлөөнд автахгүйгээр ажлаа ил тод явуулж, үр дүнг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилна.

2.6 Барилга байгууламж, тоног төхөөрөмжийг иж бүрэн буюу хэсэгчилсэн байдалаар нь үнэлэх сонгон шалгаруулалт хийж болно.

Гурав. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журам

3.1 Сонгон шалгаруулалтад хамрагдах мэргэжлийн үнэлгээний байгууллагыг

шалгаруулахдаа Засгийн газрын 1995 оны 38 дугаар тогтоолоор баталсан төсөл шалгаруулах журмыг мөрдлөг болгоно.

3.2 Сонгон шалгаруулалтын зарыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэх бөгөөд сонгон шалгаруулалтад оролцох үнэлгээний мэргэжлийн байгууллага хүсэлт, шаардагдах мэдээллийг сонгон шалгаруулах ажлын хэсэгт заасан хугацаанд ирүүлнэ.

3.3 Сонгон шалгаруулалтад оролцох байгууллага сонгон шалгаруулах ажлын хэсгээс тэмдэгт дарж баталгаажуулсан тусгай маягтаар доорх баримтыг бүрдүүлж нууцлан ирүүлнэ. Үүнд:
- сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт
- байгууллагын тухай товч танилцуулга
- сүүлийн 3 жилд үнэлгээ хийсэн томоохон /Зхүртэл/аж ахуйн нэгжийн жагсаалт
- сонгон шалгаруулалтаар зарлагдсан үнэлэгдэх хөрөнгөтэй ижил төстэй ажил гүйцэтгэсэн тухай мэдээлэл
- үнэлгээний ажилд оролцох үнэлгээний судалгаа /анкет/

- үнэлгээний ажлыг гүйцэтгэх, зохион байгуулах аргачлал болон гүйцэтгэх хугацаа, ажлын хөлсийг тусгасан санал, гэрээний төсөл
- хураамж төлсөн тухай төлбөрийн даалгаврын хуулга.

3.4 Шалгаруулалтын материал нь үг үсэг, тоо, шифрийн зөрүүгүй, үнэн зөв, цэвэр нямбай, засваргүй хийгдсэн байвал зохино. Сонгон шалгаруулах ажлын хэсгийн олгосон маягтыг хуулах, олшруулахыг хориглоно.

3.5 Үнэлэгдэх хөрөнгийн онцлогоос харгалзан сонгон шалгаруулалтыг нэг ба хоёр үе шаттайгаар явуулж болно.

3.6 Энэ журмын 3.3 -т дурдсан баримт, материалуудыг Сонгон шалгаруулах ажлын хэсэг хүлээн авч 3-аас доошгүй гишүүнийг байлцуулан задалж, ирүүлсэн баримт бичгийн иж бүрдэлтийг шалган, ажлын хэсгийн нарийн бичгийн дарга хүлээн авч битүүмжлэн шалгаруулалтын шатанд шилжүүлнэ. Материалаа дутуу бүрдүүлсэн байгууллагыг сонгон шалгаруулалтад оруулахгүй.

3.7 Нэг үе шаттай сонгон шалгаруулалтын үед иж бүрдлийг шалгаж, бэлэн болсон материалыг Гүйцэтгэгчийн дэвшүүлсэн үнэ, гүйцэтгэх хугацааны санал, ажлын чанарын болон болзошгүй тохиолдолд үүсэх хариуцлагын талаар холбогдох байгууллагаас гаргасан баталгаа, тодорхойлолтын хамт нэг мөр авч үзэж шалгаруулалт явуулна.



3.8 Хоёр үе шаттай сонгон шалгаруулалтын анхан шатны шалгаруулалтаас дараагийн үе шатанд шалгарсан тухай гүйцэтгэгч нарт сонгон шалгаруулах комиссоос мэдэгдэл өгч тэдний дэвшүүлсэн санал, баталгаа, тодорхойлолттой нарийвчлан танилцсаны үндсэн дээр тодотгох, шинэчлэх боломжоор хангана. Тогтоосон хугацаанд тодотгож шинэчилсэн санал, баталгааг нууцлан битүүмжилж сонгон шалгаруулах комисс хүлээн авч шалгаруулна.

3.9 Сонгон шалгаруулах ажлын хэсэг ирүүлсэн баримт, саналыг нарийвчлан судалж, Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг гишүүдийн 80-аас доошгүй хувийн бүрэлдэхүүнтэйгээр, саналыг нууцаар хураан, олонхийн саналаар гүйцэтгэгчийг шалгаруулж, шийдвэр гаргана. Сонгон шалгаруулалтын шийдвэрт ажлын хэсгийн дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, Сангийн яамны тэмдэг дарж баталгаажуулна.

3.10 Гүйцэтгэгч нь Сонгон шалгаруулах ажлын хэсгийн шийдвэр гарснаас хойш 10 хоногт багтаан Захиалагчтай ажил гүйцэтгэх Гэрээг Иргэний хуульд заасны дагуу байгуулж, хувийг ажлын хэсэгт ирүүлнэ. Гэрээний амлалт, үзрэг биелэгдээгүй нөхцөлд үүсэх бүх хохирол, нэмэлт зардлыг Захиалагч, Гүйцэтгэгчийн аль буруутай тал нь бүрэн хариуцна. Энэ талаар үүссэн маргааныг шүүхэд тавьж шийдвэрлүүлнэ. Найдваргүй болохоо үйл ажиллагаагаараа харуулсан Гүйцэтгэгчийг цаашид тодорхой хугацаагаар сонгон шалгаруулалтад оролцуулахгүй болсон тухай Сонгон шалгаруулах ажлын хэсэг нийтэд мэдээлнэ.

3.11 Сонгон шалгаруулалтад ирүүлсэн баримт бичгийг буцааж олгохгүй.

3.12 Сонгон шалгаруулалтын бичиг баримт, холбогдох бусад материалыг Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга хариуцан уг ажлыг бүрэн гүйцэтгэж дууссанаас хойш 3 жилийн хугацаагаар архивлаж хадгална.

Дөрөв. Сонгон шалгаруулалтын ажил үйлчилгээний үнэлгээ

4.1 Сонгон шалгаруулалтад оролцогчид нь тодорхой хураамж төлөх хэлбэрээр баталгаажуулалт хийнэ. Үнэлэгдэх хөрөнгийн онцлогоос хамаарах баталгаажуулалтын хураамж /Захиалагч, Гүйцэтгэгчээс төлөх/-ийн жишгийг Сангийн сайдын тушаалаар тогтооно.

4.2 Сонгон шалгаруулах ажил үйлчилгээнд зориулан Гүйцэтгэгчээс төлсөн хураамжийг тусгай дансанд төвлөрүүлж, ажлын хэсгийн даргын баталсан төсвийн дагуу зарцуулна.

4.3 Үнэлгээний хөлсийг хэрхэн тооцох талаар Гүйцэтгэгч, Захиалагчтай тохиролцож санал болгосон үнэлгээний хөлсийг ажлын хэсгийн шийдвэрээр батална.

Тав. Сонгон шалгаруулах үйл ажиллагаанд мөрдлөг болгох зүйл

5.1 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад ажлын хэсгийн даргын шийдвэрээр холбогдох мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж, экспертиз, дүгнэлт гаргуулж болно.

5.2 Ажлын хэсгийн гишүүд нь улс орны аюулгүй байдлыг хангах, үнэлгээний ажлыг үнэн зөв гүйцэтгэхэд онцгой анхаарах бөгөөд танил тал харах, асуудалд өрсөвлөх хандах, гадны аливаа нөлөөнд автахгүй байна.

Гишүүн нь сонгон шалгаруулалтад оролцогч байгууллагын нууц задруулсан болон хууль бус гажуудал гаргасан тохиолдолд сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс хасах арга хэмжээг эрх олгосон байгууллага авна. Шаардлагатай гэж үзвэл хуулийн байгууллагад шилжүүлнэ.

5.3 Ажлын хэсгийн даргын шийдвэрээр гишүүдэд урамшуулал, гэрээгээр ажиллагсдад хөлс тогтоож олгоно. Энэ хөлсний хэмжээ, хязгаарыг Сангийн сайдын тушаалаар тогтооно.

5.4 Сонгон шалгаруулах ажлын хэсгийн хуралд өрсөлдөгчид болон хөндлөнгийн сонирхогч этгээд шаардлагатай тохиолдолд ажиглагчаар оролцож болно.

МОНГОЛ УЛСЫН ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН ТУШААЛ

1999 оны 12 дугаар сарын 17-ны өдөр

Дугаар 275

Улаанбаатар хот

Шалгуур үзүүлэлт батлах тухай

Эрдэм шинжилгээний болон дээд боловсролын байгууллагын үйл ажиллагааг үнэлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Эрдэм шинжилгээний болон Дээд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тухайн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх шалгуур үзүүлэлтийг хавсралтын ёсоор шинэчлэн баталсугай.

боловсролын байгууллагуудын үйл ажиллагаанд жил бүрийн эцэст үнэлгээ өгч Гэгээрлийн сайдын зөвлөлийн хуралд танилцуулж байхыг Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (Л. Баттулга)-т даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Шалгуур үзүүлэлт батлах тухай" Гэгээрлийн сайдын 1998 оны 256-р тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

2. Эрдэм шинжилгээний болон Дээд

САЙД

А. БАТТӨР

Эрдэм шинжилгээний болон дээд боловсролын байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх шалгуур үзүүлэлтүүд

Эрдэм шинжилгээний болон дээд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрдэм шинжилгээний болон дээд боловсролын байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгөхдөө энэхүү шалгуур үзүүлэлт, аргачлалыг барьмтална.

1. ДЭЭД БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, ҮНЭЛГЭЭ ӨГӨХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ДҮГНЭХ АРГАЧЛАЛ

№	Үзүүлэлт	Дүгнэх аргачлал		тайлбар
1	Доктор, профессорын зэрэг цолтой багш нарын эзлэх хувийн индекс	$W = \frac{P_2}{M_1}$	P_2 - доктор, профессорын зэрэг, цолтой багшийн тоо M_1 - үндсэн багшийн тоо	Доктор, профессор зэрэг, цолыг давхар авсан хүнийг нэг гэж тооцоно.
2	Бүтээлийн индекс	$B = \frac{Z_B}{M_1}$	Z_B - тухайн жилд хэвлүүлсэн э/ш-ний бүтээл, өгүүлэлийн тоо M_1 - үндсэн багшийн тоо	Эрдэм шинжилгээний бүтээл, өгүүлэлийн тоог засгийн газрын 1998 оны 14-р тогтоолоор баталсан "Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журам"-ын 8-д зааснаар болон зөвхөн

өөрийн судалгаа,ч үр дүнд үндэслэн баримтаар нотолж, тухайн мөргөжлийн салбарт шинэ мэдлэг бий болгосон бүтээлийг тооцоно.			
$N_1^{max} \leq 1$	M_1 - үндсэн багшийн тоо M - ажиллавал зохих багшийн тоо	$N_1 = \frac{M_1}{M}$	нийт багшийн дотор үндсэн багшийн эзлэх хувийн индекс
	R_1 - төгсөөд 6 сарын дотор ажилтай болсон төгсөгчдийн тоо R - тухайн жилд төгссөн оюутны тоо	$N_2 = \frac{R_1}{R}$	төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувийн индекс
	S_T - өмнөх жилийн сургалтын төлбөр S - тухайн жилийн сургалтын төлбөр U_1 - инфляцийн өөрчлөлтийн коэффициент	$K_3 = \frac{S_T}{S} U_1$	Сургалтын төлбөрийн өсөлт, бууралтын индекс

6 Цалингийн зардал дахь багш нарын цалингийн эзлэх хувийн индекс	$K_1 = \frac{Z_I}{Z}$	Z_T -багш нарын цалингийн нийлбэр Z -Нийт ажиллагсадын цалин	
7 Урсгал зардалд оюутны төлбөрөөс бусад Засгийн газрын бус санхүүжилтын эзлэх хувийн индекс	$K_2 = \frac{S_{MO}}{S_G}$	S_G -урсгал зардлын хэмжээ S_{MO} -Оюутны төлбөрөөс бусад засгийн газрын бус санхүүжилт	$K_2^{max} = 1$
8 Сургалттай холбоотой зардлын индекс	$K_1 = \frac{B_1}{C}$	B_1 -сургалттай холбогдох зардал C -нийт зардал	Гэгээрлийн сайдын 1999 оны 107-р тушаалаар баталсан "Их сургууль, коллежийн төсөв зохиох, сургалтын төлбөрийг тодорхойлох үлгэрчилсэн аргачлал"-д заасан холбогдох зардлын төрлөөр тооцох.
9 Оюутны байрны хангамжийн индекс	$F_2 = \frac{A_3}{A_4}, A_3 < A_4$ $A_3 \geq A_4 \rightarrow F_2 = 1$	A_3 -байранд сууж буй оюутны тоо A_4 -байранд суух шаардлагатай оюутны тоо	$F_2^{max} \leq 1$ /өөр сургуулиас байранд сууж буй оюутны тоог оруулна./

10 Ном сурах бичгийн хангамжийн индекс	$T_1 = \frac{D_1}{D}$	D_1 - нэг оюутанд ногдох мэргэжлийн ном сурах бичгийн тоо D - нэг оюутанд ногдох мэргэжлийн ном, сурах бичгийн норматив тоо	
11 Сургалтын зориулалттай талбайн ашиглалтын индекс	$F_1 = \begin{cases} A_1, & A_1 \leq A_2 \\ A_2, & A_1 > A_2 \end{cases}$	A_1 - өдрийн ангийн нэг оюутанд ногдох ашигтай талбайн хэмжээ, /м ² / A_2 - нэг оюутанд ногдох норматив талбайн хэмжээ, /м ² /	$A_1 > A_2$ үед $F_1^{max} = 1$ гэж тооцно

Үнэмлэг өгөх

1. Дээд боловсролын байгууллагад тухайн жилд дэвшүүлсэн зорилт болон үйл ажиллагааныхаа зорилтуудыг хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээ гарсан үр дүн, үнэмлэгэ тайландаа тодорхой бичиж, тооцоо судалгааг хавсарган жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны дотор Гэгээрдлийн яаманд ирүүлэнэ.

2. Дээд боловсролын байгууллагуудын тайлан болон бусад материалд үндэстэн шалгуур үзүүлэлт, аргачлал, дараах томилог ашиглан үйл ажиллагаанд нь хяналт шинжилгээ хийж, үнэмлэгэ өгнө.

$$G = 20(N_1 + N_2 + W + T_1 + B) + 10(F_1 + F_2) + 5(K_1 + K_2 + K_3 + K_4)$$

Өгөх үнэмлэгэ: $G > 90$ бол хангалттай сайн

$65 < G \leq 90$ бол сайн

$50 < G \leq 65$ бол дунд зэрэг

$G \leq 50$ бол хангалтгүй

3. Шаардлагатай тохиолдолд дээд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны гов байгууллагаас тайланд бичигдсэн зүйлтэй газар дээр нь танилцсаны дараа үнэмлэгэ өгнө.

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ - ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, ҮНЭЛГЭЭ ӨГӨХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрдэм шинжилгээний байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөхдөө энэхүү шалгуур үзүүлэлт, аргачлалыг баримтлана.

№	Үзүүлэлт	Дүгнэх аргачлал
1.	Эрдэм шинжилгээний ажилтны хувийн индекс	$W_1 = \frac{M_1}{M_2}$ M_1 - Эрдэм шинжилгээний ажилтны тоо M_2 - нийт ажиллагсдын тоо
2.	Эрдэмийн зорго, цолтой ажилтны хувийн жингийн индекс	$W_2 = \frac{D+P}{M_1}$ D - доктор, дэд докторын тоо P - профессор, дэд профессорын тоо M_1 - Эрдэм шинжилгээний ажилтны тоо
3.	Магистр, докторант удирдаж буй эрдэм шинжилгээний ажилтны хувийн жингийн индекс	$W_3 = \frac{Z_M}{M_1}$ Z_M - магистр, докторант удирдаж байгаа ЭША-ны тоо M_1 - нийт эрдэм шинжилгээний ажилтны тоо
4.	Дээд боловсролын байгууллагад багшилж байгаа эрдэм шинжилгээний ажилтны хувийн жингийн индекс	$W_4 = \frac{Z_B}{M_1}$ Z_B - багшилж байгаа эрдэм шинжилгээний ажилтны тоо M_1 - нийт эрдэм шинжилгээний ажилтны тоо
5.	Цалингийн индекс	$Z_2 = \frac{Z_2}{Z}$ Z_2 - нийт цалин Z - нийт зардал
6.	Эрдэм шинжилгээний ажилтан, ИТА-ны цалингийн индекс	$Z_1 = \frac{Z_1}{Z_2}$ Z_1 - Эрдэм шинжилгээний ажилтан, инженер техникийн ажилтны цалингийн нийлбэр Z_2 - нийт ажиллагсдын цалингийн нийлбэр
7.	Эрдэм шинжилгээний ажилтны цалингийн индекс	$Z_3 = \frac{Z_{ZC}}{Z_B}$ Z_{ZC} - Эрдэм шинжилгээний ажилтны дундаж цалин Z_B - нийт эрдэм шинжилгээний байгууллагын эрдэм шинжилгээний ажилтнуудын дундаж цалин
8.	Эрдэм шинжилгээний ажлын зардлын индекс	$Z_4 = \frac{Z_{ZC}}{Z}$ Z_{ZC} - эрдэм шинжилгээний зардал Z - нийт зардал
9.	Хөрөнгө оруулалтын өсөлтийн индекс	$I_1 = \frac{I_n}{\alpha \cdot I_{n0}}$ I_n - тухайн жилийн хөрөнгө оруулалт α - тухайн жилийн инфляцийн коэффициент I_{n0} - нийт зардал

10	Орлогын индекс	$I_1 = \frac{I_1}{Z}$	I_1 - тухайн жилийн нийт орлого Z - нийт зардал
11	Мэдээлэл хангамжийн өсөлтийн индекс	$I_3 = \frac{I_3}{\alpha \cdot I_{90}}$	I_3 - тухайн жилд мэдээлэл авах зардал α - тухайн жилийн инфляцийн коэффициент I_{90} - өмнөх жилд мэдээлэл авахад зарцуулсан зардал
12	Лабораторийн тоног төхөөрөмжийн хангамжийн индекс	$T = \frac{\sum_{i=1}^n T_i}{N_0}$	i - ашиглалтанд байгаа техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн дугаар T_i - i -дугаар тоног төхөөрөмжийн хангамжийн коэффициент (0-ээс 1 хүртэлх интервалд утгаа авч.) N_0 - шаардагдах тоног төхөөрөмжийн тоо
13	Шинжлэх ухаан, технологийн төслийн индекс	$K = \frac{P_1}{M_1}$	P_1 - хэрэгжж байгаа дотоод, гадаадын төслийн нийт тоо M_1 - Эрдэм шинжилгээний ажилтны тоо
14	Үр дүнгийн индекс	$B = \frac{N_1}{M_1}$	N_1 - тухайн жилд гарсан үр дүнгийн тоо M_1 - нийт эрдэм шинжилгээний ажилтны тоо
15	Нэвтэрсэн үр дүнгийн ашгийн индекс	$R = \frac{R_n}{R_1}$	R_n - тухайн жилд нэвтэрсэн үр дүнгээс олсон нийт орлого R_1 - үр дүнг нэвтрүүлэхэд гарсан нийт зардал

Үнэлгээ өгөх

1. Эрдэм шинжилгээний байгууллагууд тухайн жилд дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, гарсан үр дүнг, үнэлгээг тайландаа тодорхой бичиж, холбогдох тооцоо, судалгаа болон эдгээр үзүүлэлтүүдийн индексийг аргачлалын дагуу гаргаж хавсарган жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны дотор Г-гээрлийн яамны Мэдээлэл, хангалт-шинжилгээ, үнэлгээний газарт ирүүлнэ.

2. Эрдэм шинжилгээний байгууллагуудын тайлан болон бусад материалд үндэслэн шалгуур үзүүлэлт, аргачлал, дараах томъёог ашиглан үйл ажиллагаанд нь үнэлгээ өгнө.

$$G = 10(W_1 + W_2 + W_3 + W_4) + 8(Z_1 + Z_2 + Z_3 + Z_4 + 1) + T + k + 5(I_1 + I_3) + 15(B + R)$$

бол маш сайн $G > 80$

65 < G ≤ 80 бол сайн
 50 < G ≤ 65 бол дунд зэрэг
 G ≤ 50 бол хангалтгүй

3. Шаардлагатай тохиолдолд шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тайланд бичигдсэн зүйлтэй газар дээр нь танилцаж үнэлгээ өгнө.

Тайлбар: а. Эрдэм шинжилгээний ажилтны дундаж цалингийн индексийг тодорхойлохдоо нийт эрдэм шинжилгээний байгууллагын эрдэм шинжилгээний ажилтны дундаж цалин Z_a -гийн мэдээллийг ШУТС-аас авна.
 б. Төслийн үр дүнгийн тоог гаргахдаа Засгийн газрын 1998 оны 14 дүгээр тогтоолоор баталсан "Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журам"-д заасан хэлбэр тус бүрээр гаргаж нийлбэрчилнэ.
 в. Бүх индекс 0-ээс 1 хүртэлх интервалд утгаа авна. Зарим индексийг тооцоолоход утга нь 1-ээс их гарвал түүний максимум утгыг 1 гэж тооцно.



МОНГОЛ УЛСЫН ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН ТУШААЛ

1999 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр

Дугаар 313

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 100 дугаар тогтоолын 2-р заалт, "Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм"-ийн 9-р заалтуудыг үндэслэж ТУШААХ нь:

1. "Үл хөдлөх хөрөнгө үнэлэхэд зориулж барилга байгууламжийн чанарт техникийн дүгнэлт

өгөх журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Энэхүү журмын дагуу техникийн дүгнэлт гаргах, түүний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дэд бүтцийн улсын хяналтын албаны дарга /н. Пхагваа/-д даалгасугай.

САЙД

Г.БАТХҮҮ

Дэд бүтцийн хөгжлийн сайдын 313 тоот тушаалын хавсралт

ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ ҮНЭЛЭХЭД ЗОРИУЛЖ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЧАНАРТ ТЕХНИКИЙН ДҮГНЭЛТ ӨГӨХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Үл хөдлөх хөрөнгө үнэлэхэд зориулж барилга байгууламжийн чанарт техникийн дүгнэлт өгөх, түүнийг гүйцэтгэх эрх олгох, тэдгээрт хяналт тавихтай холбоотой үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмыг баримтлана.

2. Техникийн дүгнэлт гаргагч нь монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, барилгын норм ба дүрэм, заавар зөвлөмж, стандартуудыг үндэслэн гүйцэтгэнэ.

Хоёр. Эрх олгох

1. Үл хөдлөх хөрөнгө үнэлэхэд зориулж барилга байгууламжийн чанарт техникийн дүгнэлт өгөх эрхийг барилгын байгууллагад 10 жил, үүнээс зураг төслийн байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан тухайн мэргэжлээр зөвлөх, тэргүүлэх зэрэгтэй, барилга, цахилгаан, халаалт салхивч, цэвэр бохир ус, механикийн мэргэжилтэй инженер /цаашид гүйцэтгэгч/-т олгоно.

2. Техникийн дүгнэлт гаргах эрх авахыг хүссэн гүйцэтгэгч өргөдөл, мэргэжлийн болон зэрэг дэвийн дипломын хуулбарыг нотариатаар батлуулан Дэд бүтцийн улсын Хяналтын албанд ирүүлнэ.

3. Дэд бүтцийн Улсын хяналтын алба ирүүлсэн материалтай уялцаж, дүгнэлт өгөх эрхийг жилд 1 удаа олгоно.

4. Гүйцэтгэгч техникийн дүгнэлтээ бусдын нөлөөлөлд автахгүй үнэн зөв гаргана.

Гурав. Техникийн дүгнэлт гаргах

1. Гүйцэтгэгч нь барилга байгууламжийн төлөв байдал, холбогдох баримт бичгийг судалсны үндсэн дээр Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм, барилгын салбарт мөрдөгдөж

буй хууль, барилгын норм ба дүрэм, стандарт, заавар зөвлөмжтэй уялдуулан энэ журмын 1 дүгээр хавсралтын дагуу техникийн дүгнэлт өгч, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээнд тусгах итгэлцүүрийг тогтооно.

2. Гүйцэтгэгч барилга байгууламжтай танилцсаны дараа техникийн дүгнэлтийг гаргах гэрээг захиалагчтай хийнэ.

3. Гүйцэтгэгч техникийн дүгнэлтийг гэрээнд заасан хугацаанд захиалагчид гаргаж өгнө.

4. Дүгнэлт гаргах үнэ хөлсийг Дэд Бүтцийн Улсын Хяналтын албанаас баталсан журмын дагуу тодорхойлж гэрээнд тусгана.

5. Техникийн дүгнэлтийг 4хувь үйлдэж, Дэд Бүтцийн Улсын Хяналтын Алба, аймаг нийслэлийн барилгын техникийн улсын байцаагчид тус бүр 1 хувийг өгч хянуулан бүртгүүлнэ.

6. Техникийн дүгнэлтийг бүртгүүлсний дараа үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний байгууллагад өгч барилга байгууламжийн үнэлгээ хийлгүүлнэ.

7. Барилга байгууламжийн чанар байдлыг тодорхойлж байгаа гүйцэтгэгч нь энэ журмын 1-р хавсралтын дагуу дүгнэлт өгч, гарын үсэг зуран, тэмдэг дарж баталгаажуулна.

Дөрөв. Дүгнэлт гаргагчдын ажилд хяналт тавих

1. Дэд Бүтцийн улсын хяналтын алба барилга байгууламжийн чанарт гаргасан техникийн дүгнэлтэд хяналт тавьж, гарсан маргааныг хянан шийдвэрлэнэ.

2. Дэд Бүтцийн Улсын Хяналтын



Албанаас шаардлага хангахгүй техникийн дүгнэлт гаргасан гүйцэтгэгчийг, үйл ажиллагаа явуулах эрхийг нь хүчингүй болгож хариуцлага тооцно.

3. Дүгнэлтийг хянаж үзээд шаардлага хангасан тохиолдолд бүртгэж, үнэлгээ хийлгэх зөвшөөрөл олгоно.

4. Орон нутгийн барилгын техникийн хяналтын байцаагчид нь бүртгэсэн жагсаалт болон техникийн дүгнэлтийг улирал Бүр Дэд Бүтцийн Улсын Хяналтын албанд ирүүлж байна.

5. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн асуудал болон барилгын техникийн хяналтын асуудал хариуцсан Засгийн газрын агентлагууд хамтран байгуулсан зөвлөл нь барилга байгууламжийн чанарыг тодорхойлох техникийн дүгнэлт үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг хянаж зөвшөөрнө.

6. Энэ зөвшөөрлийг үндэслэн үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн газар барилга байгууламжийг улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгох асуудлыг шийдвэрлэнэ.

Журмын 1-р хавсралт

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВ БАЙДАЛД ЧАНАРЫН ҮНЭЛЭЛТ ӨГСӨН ТЕХНИКИЙН ДҮГНЭЛТ

Бүртгэлийн дугаар ...

(судалгаа хийсэн объектын нэр)

(судалгаа дүгнэлт боловсруулсан байгууллага)

Дүгнэлт хийсэн (гарын үсэг) / /

Агуулга

- | | |
|-------------------|----------|
| 1. Дүгнэлт тайлан | ш хуудас |
| 2. Хавсралт | ш хуудас |
| 3. Зураг | ш хуудас |



БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВ БАЙДАЛД ЧАНАРЫН ҮНЭЛГЭЛТ ӨГСӨН ТЕХНИКИЙН ДҮГНЭЛТ

1. Ерөнхий өгөгдөл

- 1.1. Барилгын нэр хүчин чадал
- 1.2. Байршил /хот, аймаг, сум, дүүрэг, хороо, гудамж, номер, дугаар/
- 1.3 Өмчлөгч байгууллага
- 1.4 Зураг төслийг боловсруулсан байгууллага, зохиогч
- 1.5 Зураг төсөл боловсруулсан он, сар өдөр шифр
- 1.6 Барилгын талбайн инженер геологийн нөхцөл, буурь хөрсний нэр төрөл хөрсний усны төвшин

- 1.7 Барилгыг тооцсон газар хөдлөлтийн балл
- 1.8 Барилга баригдаж эхэлсэн он сар, өдөр
- 1.9 Барилга баригдаж дууссан он сар, өдөр
- 1.10 Барилгын гүйцэтгэгч байгууллагын нэр
- 1.11 Барилгын ашиглалтын технологийн горим байдал

2. Барилгын үндсэн үзүүлэлт

- 2.1 Барилгын төрөл
- 2.2 Давхрын өндөр, тоо
- 2.3 Барилгын хэмжээ: Барилгын урт, өргөн, өндөр м
- 2.4 Барилгын эзэлхүүн м³

3. Үндсэн бүтээц элементийн үзүүлэлт

Энэ бүлэгт үндсэн хийц бүтээцүүдийн төлөв байдал ямар байгаа, норм дүрмийн шаардлагыг хэрхэн хангаж байгаа, эвдрэл гэмтлийн байдал, газар хөдлөлийн үйлчлэл, болон аюулгүй хэвийн ашиглах нөхцөл хир зэрэг хангаж байгаа талаар хийц бүтээцүүдээр тодорхой бичнэ.

3.1 Суурь

3.2 Багана, дам нуруу

3.3 Хана, хамар хана

3.4 Хучилт, төмөр бетон бүс

3.5 Ялуу, ханын арматурлалт

3.6 шат

3.7 Дээвэр

3.8 Ялуу, ханын арматурлалт

3.9 Бусад

4. Тоосгон барилгын нэмэлт үзүүлэлт

4.1 Тоосгоны марк, зуурмагийн марк

4.2 Тоосгон өргийн барьцалдалтын эсэргүүцэл

4.3 Өргийн газар хөдлөлтийг эсэргүүцэх чадварын категори

4.4 Барилгын ханын уулзварын арматурчлалт

4.5 Дөр ханын босоо арматурчлал

5. Барилгын хийц бүтээцэд хийсэн судалгаа туршилтын үр дүн

Шаардлагатай тохиолдолд барилгын хийц бүтээцэд нарийвчилсан судалгаа хийнэ.

6. Барилгад хийсэн инженерийн тооцоо Гэмтсэн барилгын бүтээц, тэдгээрийн элементүүдийн шалгалтын тооцоог хийнэ.

7. Барилгын талаарх дүгнэлт, зөвлөмж Барилгын үндсэн хийц бүтээцүүдийн төлөв байдал, түүнийг, цаашид хэрхэн ашиглах, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээнд эдгээр нь хэрхэн нөлөөлөхийг тодорхойлно.

8. Хавсралт материалууд

8.1 Барилгын хийц элементээс дээж авч бат бэхийг тодорхойлсон үр дүн

8.2 Зураг, фото, гүйцэтгэл

8.3 Хэмжилтийн зураг

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВ БАЙДАЛД
ӨГСӨН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ

№	А.Бүтээгчийн үнэлэм байдал		Б.Норм журмын шаардлагыг заах		В.Эдгээр гэмтлийн байдал			Г.Гагар хэдэнхэд үнэлэм төлөөгүй юм?			Өргөсний үнэлэм $K = (A+B+C+G)/4$			
	Сайн	Дунд	Бүтэн залгах	Ашиг- лах болон- той	Хан- галт- гүй	Нойр той вад ы	Эх роа гэмт эл	Хөн гэмт эл	Тус- вр- тай	Норм хан- галгүй болон засах сайжруулах боломтой	Норм хан- галтгүй болон болон	Сайн	Дунд	Муу
1.	1-0.85	0.84- 0.68	1-0.85	0.84- 0.68	0.55- 0.68	0.55 0.68	0.84 0.69	1.	1	0.84-0.68	0.55- 0.68	1-0.85	0.84- 0.68	0.68
2.														
3.														
4.														
5.														
6.														
7.														
8.														
9.														
10.														
11.														
12.														
13.														

Тайлбар:

1. Барилга байгууламжийн төлөв байдалд чанарын үнэлгээ өгөхдөө дээрх хүснэгтийн дагуу тухайн барилга байгууламжийн хийц элементүүдийн нэр төрлийг сонгон авч тохирох итгэлцүүрийг өгнө.
2. Барилгын ерөнхий итгэлцүүрийг тодорхойлохдоо K_1 үзүүлэлтийн арифметик дундажаар гаргана. Барилгын ерөнхий итгэлцүүр $K = (Σ K_i) / n$
3. Хэсэг тус бүрийн ерөнхий үнэлгээний нийлбэрийг авно. Үүний нийт арифметик дундаж утгыг олсноор барилгын чанарын түвшин тодорхойлогдох юм.
4. Барилгын чанарын ерөнхий итгэлцүүрээр үл хөдлөх хөрөнгө үнэлгээг уржүүлж уул барилгын бодит үнэлгээг гаргана.

Барилгын үндсэн хийц бүтээгчийн нэр – гэсэн баганад тухайн чанарыг тодорхойлж буй барилга байгууламжийн барилгын үндсэн хийц бүтээгчийн тохирох нэрийг бичнэ



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

1999 оны 6 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар 443

Улаанбаатар хот

Дэд хөтөлбөр батлах тухай

Цагдаагийн ерөнхий газрын даргын дэргэдэх зөвлөлийн энэ оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 11 дүгээр хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ НЬ:

2. "Цагдаагийн байгууллагын хэсгийн төлөөлөгч болон цагдаа нарын тогтвортой үйл ажиллагааг хангах дэд хөтөлбөр"-ийг энэ оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

1. " Цагдаагийн байгууллагын хэсгийн төлөөлөгч болон цагдаа нарын тогтвортой үйл ажиллагааг хангах дэд хөтөлбөр"-ийг баталсугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Д.МӨРӨН

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГИЙН ХЭСГИЙН ТӨЛӨӨЛӨГЧ БОЛОН ЦАГДАА НАРЫН ТОГТВОРТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХ ДЭД ХӨТӨЛБӨР

1999 оны 6 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

Цагдаагийн байгууллага, гэмт хэрэгтэй тэмцэх нийгмийн хэв журам хангах, үндсэн үүргээ биелүүлэх явдал нь засаг захиргааны нэгж, сумдад ажиллаж байгаа хэсгийн төлөөлөгч болон цагдаа нарын үйл ажиллагаанаас ихээхэн шалтгаалдаг. Хэсгийн төлөөлөгч болон цагдаа нар нь ард иргэдтэй хамгийн ойр дот ажилладаг, цагдаагийн байгууллагын өвөрмөц олон талт үйл ажиллагааг бие даан явуулдаг төвөөс алслагдмал холбоо мэдээллээр гачигдмал, хүч, хэрэгслийн хувьд дутагдалтай, хүнд нөхцөлд ажиллаж амьдарч байна.

байгаагийн 166 нь буюу 63.8 хувь нь хэсгийн төлөөлөгчийн дамжаа төгссөн, 17 нь буюу 6.6 хувь нь дамжаа төгсөөгүй 159 нь, буюу 61.9 хувь нь хуульч мэргэжилтэй, бусад нь өөр мэргэжлийн буюу мэргэжилгүй алба хаагч байна.

Сумдад ажиллаж байгаа хэсгийн төлөөлөгч болон цагдаа нараас цагдаагийн байгууллагын удирдлага, тогтвортой үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхой болгох зорилгоор энэхүү хөтөлбөрийг боловсруулав.

1995-1999 онд хэсгийн төлөөлөгч нарын 72 нь буюу 27.7 хувь нь давтан сургалтад хамрагджээ. Дунджаар нэг хэсгийн төлөөлөгч, цагдаа 4.3 ам бүлтэй. сарын өрхийн орлого 47.3 мянган төгрөг, нэг хүнд ноогдох орлого 11 мянган төгрөг байна. Ховд, Увс, Баянхонгор, Баян-Өлгий, Дорнод, Өвөрхангай Хөвсгөл зэрэг аймагт өрхийн нэг хүнд ноогдох орлого дээрх дундаж хэмжээнээс 1000-4730 төгрөгөөр доогуур байна.

Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 55 дугаар тогтоолоор бүсчилэн тогтоосон амьдралын баталгаажих доод түвшингийн хэмжээнээс хэсгийн төлөөлөгчийн нэг хүнд ноогдох орлого Ховд аймагт 3455, Увс аймагт 2487, Баян-Өлгий аймагт 1160, Дорнод аймагт 1000 төгрөгөөр тус тус доогуур байна.

Хөтөлбөрийн зорилго

1. Цагдаагийн байгууллагын удирдлага, тогтвортой үйл ажиллагааны хөтөлбөрт цагдаагийн байгууллага, түүний төрөл албадын чиглэлээр тодорхой тусгасан учир энэхүү хөтөлбөрөөр сумдын хэсгийн төлөөлөгч болон цагдаа бүрэлдэхүүний үүргээ биелүүлэх боломж, баталгааг бүрэн хангах, тэдний үйл ажиллагааг иргэдэд ойлгуулж, ойртуулах, тэдний боловсрол мэдлэг мэргэжлийг дээшлүүлэхэд дэд хөтөлбөрийн зорилго оршино.

Хэсгийн төлөөлөгч нарын гэр бүлийн 69 гишүүн засаг захиргааны болон аж ахуйн байгууллагад ажил эрхэлж бусад нь тодорхой ажил эрхлээгүй байна.

Хэсгийн төлөөлөгч нарын 92 нь амины гэр, орон сууцтай, 49 нь амины малтай, 39 нь амины машин, мотоцикльтой, 19 алба хаагч өөрийн төрж өссөн сумандаа ажиллаж амьдарч байна.

2. Энэхүү дэд хөтөлбөр нь 2005 он хүртэл цагдаагийн байгууллага, албанаас хэсгийн төлөөлөгч болон цагдаа нарын үйл ажиллагааг тогтворжуулахад баримтлах үндсэн баримт бичиг мөн.

1999 оны байдлаар улсын хэмжээнд 21 аймагт 63 хэсгийн төлөөлөгч дутуу байснаас Цагдаагийн дээд сургуулийн энэ оны төгсөлтөөс 18 аймагт 48 алба хаагчийг энэ албан тушаалд томилсон ба одоо 8 аймагт 15 хэсгийн төлөөлөгч томилогдоогүй байна.

Нэг. Хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын ажил, нийгмийн асуудлын өнөөгийн байдал

1999 оны 6-р сарын 15 ны байдлаар улсын хэмжээнд 260 хэсгийн төлөөлөгч ажиллаж

Хөёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэх арга хэмжээ



1. Цагдаагийн байгууллагын хэсгийн төлөөлөгч болон цагдаа нарын талаар Зэсгийн газрын тогтоол гаргаж дараах асуудлуудыг шийдвэрлүүлнэ.

а/ Хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын алба ажлаа явуулахад нь шаардагдах бүх зардлыг орон нутгийн төсвөөс хангах,

б/ 2005 он хүртэл системтэйгээр сумдад ажиллаж байгаа хэсгийн төлөөлөгч нарыг албаны машин, мотоцикл болон холбоогоор хангах арга хэмжээ авах:

в/Хэсгийн төлөөлөгч болон цагдааг тогтвор суурьшилтай ажиллах боломжийг хангах зорилгоор сууц барих, амьдралын нэн тэргүүний хэрэгцээт зүйлс худалдан авах, малжих, хүүхдээ сургахад нь зориулж хөнгөлөлттэй зээл олгох асуудлыг аймгийн засаг дарга нарт зөвшөөрөх.

Гурав. Цагдаагийн ерөнхий газраас авах арга хэмжээ

1. Хэсгийн төлөөлөгч болон цагдаагаар тогтвор сууршилтай 15 жилээс дээш хугацаагаар ажилласан хэсгийн төлөөлөгч болон цагдаа нарын ажилласан нэг жил тутамд 3 сарын нэмэгдэл олгож улсад ажилласан жилд оруулж тооцож байх талаар цагдаагийн байгууллагын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах:

2. Хэсгийн төлөөлөгчөөр 15-аас дээш жил ажилласан алба хаагчид зэрэг дэвээс нэг дээгүүр цол шагнаж байх:

3. 2000 оныг хэсгийн төлөөлөгч болон цагдаагийн он болгож болзол уралдаан зарлан шалгаруулж тэргүүний хэсгийн төлөөлөгч болон цагдаа нарын улсын зөвлөлөгөөн хийлгэх:

4. Хэсгийн төлөөлөгч болон цагдаа нарыг давтан сургах, дамжаа хичээллүүлж, тэднийг сургах, гадаадын курс, семинаруудад хэсгийн төлөөлөгч нараас түлхүү оруулах бодлого барих:

5. Хэсгийн төлөөлөгч болон цагдаа нарын ажлыг нэгтгэн дүгнэх ажлыг нь системчлэх 2-3 сумын дунд цагдаагийн хэсгийн зохион байгуулалтад оруулж болох эсэхийг туршиж шийдвэрлэх:

6. Хууль зүйн яамтай хамтран "хэсгийн төлөөлөгч" гарын авлага бэлдэн гаргах:

7. Тогтвор суурьшилтай, сайн ажиллаж байгаа хэсгийн төлөөлөгч болон цагдаа нарын дотроос жил бүр 5- аас доошгүй албан хаагчийг төрийн одон, медальд тодорхойлж байх:

8. Тогтвор суурьшилтай ажиллаж аж амьдралаа зөв зохицуулж байгаа хэсгийн төлөөлөгч болон цагдаа нарын туршлагыг хэвлэл,

мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг зохион байгуулах:

9. Тогтвор суурьшилтай, аж амьдралаа зөв зохицуулж, сайн ажиллаж байгаа4-өөс доошгүй хэсгийн төлөөлөгч болон цагдаа нарыг гэр бүлийн хамт Цагдаагийн ерөнхий газрын зардлаар Үндэсний баяр наадам, Цагдаагийн баярыг үзүүлж, хүндэтгэл үзүүлэх:

10. Тогтвор суурьшилтай сайн ажиллаж байгаа хэсгийн төлөөлөгч болон цагдаа нарын Ерөнхий боловсролын сургуулийн 10 дугаар анги төгссөн, сурлага сайтай, цаашид эцгийн мэргэжлийг өвлөх боломжтой 2 хүүхдийг Цагдаагийн их сургуульд урилгаар суралцуулах бололцоо олгох:

11. Хэсгийн төлөөлөгч болон цагдаа нарын ажиллах, амьдрах бололцоо нөхцлийг шийдэхэд анхаарч дэмжиж тусалсан аймаг, сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, Засаг дарга 5-аас доошгүй хунийг аймгийн цагдаагийн газар, хэлтсийн санал, тодорхойлолтыг үндэслэн жил бүр шагнаж урамшуулах арга хэмжээ авах:

12. Хэсгийн төлөөлөгч болон цагдаа нарын цалингийн сүлжээнд өөрчлөлт оруулж, нэмэгдүүлэх арга хэмжээ авах:

13. Жил бүр монголын цагдаагийн байгууллагын хэсгийн аврага төлөөлөгч шалгаруулж байх:

14. Эрүүгийн нөхцөл байдал хүнд, хүн ам олноор суурьшсан, төв зам дайран өнгөрдөг болон хилийн зарим сумдын хэсгийн төлөөлөгч нарт жил бүр 5-аас доошгүй мотоциклыг албан ажлын хэрэгцээнд зориулж хангах арга хэмжээ авах:

15. Эрүүгийн нөхцөл байдал хүнд, авто болон төмөр замын дагуух хилийн сумдын хэсгийн төлөөлөгч нарыг шуурхай холбоогоор хангах арга хэмжээ авах:

а/ Төв, Архангай, Сэлэнгэ, /Зүүнхараа/, Орхон, Дархан уул аймгийн төмөр замын болон засмал замын дагуух сумдыг 1999-2000 он:

б/ Говьсүмбэр, Дорноговь аймаг /Замын үүд/, Багануур, Багахангай дүүргийн зарим сумдыг 2000-2001 он:

в/ Дундговь, Өмнөговь, Сүхбаатар, Дорнод, Хэнтий аймгийн зарим сумдыг 2001-2002 он:

г/ Булган, Хөвсгөл, Баянхонгор аймгийн зарим сумдыг 2002-2003 он:

д/ Завхан, Говь-Алтай, Баян-Өлгий, Ховд, Увс аймгийн зарим сумдыг 2000-2004 он.

Дөрөв. Цагдаагийн газар, хэлтсээс аймаг, сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга нарт тавьж шийдвэрлэх асуудал

1. Хэсгийн төлөөлөгч болон цагдааг тухайн сумдад томилохдоо сумын засаг дарга, цагдаагийн газар, хэлтсийн дарга, хэсгийн төлөөлөгч болон цагдаа нарын гурвалсан гэрээ байгуулж, уг гэрээнд хүлээх үүрэг хариуцлага, шийдвэрлэх асуудлыг бүрэн тусгаж жил тутам дүгнэж байх:

2. Хэсгийн төлөөлөгч болон цагдаа нарыг тогтвор суурьшилтай ажиллуулж, ажлын дадлага суулгах иргэд олон түмэнд ойртуулах ажлыг төрөл бүрээр зохион байгуулж үр дүнг тооцож хөтөлбөрийн хүрээнд дүгнэж байх:

3. Хэсгийн төлөөлөгч болон цагдаа нарын сургалт, дадлага, семинар, зөвлөгөөний тусгай график төлөвлөгөө хийж дүгнэж байх:

4. Тэргүүний хэсгийн төлөөлөгч болон цагдаа нарын ажлын ололтыг өргөн

сурталчилж "Цагдаа" сэтгүүлээр тогтмол мэдээлж байх:

5. Хэсгийн төлөөлөгч болон цагдаа нарын дунд туслах аж ахуй хөгжүүлэх, малжуулах, ногоо тарих, цагаан идээ хийх зэрэг хөдөлгөөн өрнүүлэх, тэдний гэр бүлийг хөхүүлж дэмжих талаар тодорхой ажил зохиох:

6. Хэсгийн төлөөлөгч болон цагдаа нарын гэр бүлийг тухайн орон нутагт томилогдон очсоноос хойш 3 сарын дотор ажилтай болгох арга хэмжээ авах.

Цагдаагийн Ерөнхий газрын Захиргааны удирдлагын газар, энэхүү дэд хөтөлбөрийн явц, биелэлтийг хагас, бүтэн жил дутам дүгнэж Цагдаагийн ерөнхий газрын даргад танилцуулж байна.

Жич: Сумдад удаан жил ажилласан хэсгийн байцаагч, замын цагдаагийн байцаагч нарт нэгэн адил хамаарна.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

1999 оны 10 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 647

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Дотоодын цэргийн бодлого, тогтвортой үйл ажиллагааны дэд хөтөлбөрийн 8 дугаар заалтыг хэрэгжүүлэхийн тулд ТУШААХ НЬ:

1. "Дотоодын цэрэгт алба хаах дайчдыг сонгон авах журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Журмыг хэрэгжүүлж ажиллахыг Төв,

орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн дарга нарт, журмын биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Дотоодын цэргийн штаб /Хурандаа Т.Хүрэлбаатар/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Д.МӨРӨН



Цагдаагийн ерөнхий газрын даргын 1999 оны
647 тоот тушаалын хавсралт

ДОТООДЫН ЦЭРЭГТ ЦЭРЭГ СОНГОН АВАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

1. Улсын онц чухал объектыг хамгаалах, нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэргийг таслан зогсооход оролцох болон хуулиар хүлээсэн дотоодын цэргийн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх шаардлагад тэнцэх залуучуудыг судалж, сонгон авахад энэ журмын зорилго оршино.

2. Дотоодын цэрэгт бие бялдар, эрүүл мэнд, боловсрол, хүмүүжил, сэтгэл зүйн бэлтгэл, ар гэрийн амьдрал, байдал алба хаахад сөрөг нөлөөгүй байхыг шаардана.

Хоёр. Бие бялдар, эрүүл мэндэд тавих шаардлага

1. Бие бялдарын зөв хөгжилтэй эрүүл чийрэг байна.

2. Эрүүл мэндийн хувьд тайван цагт цэргийн албанд тэнцэх эмч нарын зөвлөлгөөний дүгнэлттэй байна.

3. Суурь өвчингүй, бие эрхтний ямар нэгэн эмгэг бэртэлт, согоггүй байна.

Гурав. Боловсрол, мэргэжлийн шаардлага

1. Бүрэн ба бүрэн бус дунд боловсролтой байхаас гадна аль болох тусгай мэргэжлийн болон их, дээд сургууль, коллеж төгссөн залуучуудыг сонгоход түлхүү анхаарна.

Дөрөв. Хүмүүжил, ёс зүйд тавих шаардлага

1. Ёс зүйн болон зан суртхууны зөрчил дутагдал гаргаж байгаагүй, ял шийтгэлгүй байна.

2. Ар гэрийн гачигдал зовлонгүй, ар гэр,

найз нөхдийн зүгээс үзүүлэх дарамт шахалтгүй залуучууд байна.

Тав. Сонгон авах журам

1. Дотоодын цэрэгт алба хаах залуучуудыг судлах ажлыг орон нутгийн цагдаагийн хэсгийн байцаагч төлөөлөгч нар биечлэн хийж, дараахь асуудлаар судалгаа явуулна.

- Овог нэр
- Нас, төрсөн он, сар, өдөр
- Боловсрол мэргэжил
- Гэр бүлийн байдал
- Гэрийн хаяг
- УБ хотод байгаа ах дүүсийн тодорхой хаяг утасны дугаар
- Цэрэгт ирэхийн өмнө ямар ажил сургуульд байсан
- Сахилга ёс зүйн байдал
- Биеийн өндөр жингийн харьцаа
- Эрүүл мэндийн тодорхойлолт

2. Дотоодын цэрэгт алба хаах залуучуудыг урьдчилан сонгон судалсан материалыг цэрэг татлагаас 15 хоногийн өмнө төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн хэв журмын тасгийн дарга нар хариуцаж Дотоодын цэргийн штабт ирүүлнэ.

3. Төв, орон нутгийн цэрэг татлагын товчооны бүрэлдэхүүнд цагдаагийн газар, хэлтсээс томилогдон ажиллаж байгаа албан тушаалтан Дотоодын цэрэгт алба хаах дайчдыг судалгааны дагуу сонгон авна.

4. Энэ журмын заалтыг хэрэгжүүлж ажилллаагүй цагдаагийн тухайн албан хаагчид Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрмийн дагуу сахилгын шийтгэл оногдуулна.

МОНГОЛ УЛСЫН ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

1999 оны 12 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар 505

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Монгол Улсын Гаалийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 4, 32 дугаар зүйл, Гаалийн тарифын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 11, мөн хуулийн 29 дүгээр зүйлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлс болон автомашинд гаалийн бүрдүүлэлт хийх журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Зорчигчоос улсын хилээр татваргүй оруулах тоо хэмжээнээс хэтэрсэн бараанд ногдох гаалийн болон бусад албан татварыг ногдуулан барагдуулж байсугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Автомашинь гаалийн бүрдүүлэлтийн тухай" МУГЕГ-ын даргын 1996 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 249 дүгээр тушаал, "Журам батлах тухай" МУГЕГ-ын даргын 1997 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 48 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тушаалыг 2000 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ДАРГА

Т. ЛХАГВАА



Монгол Улсын Гаалийн Ерөнхий газрын даргын
1999 оны 505 дугаар тушаалын хавсралт

ЗОРЧИГЧИЙН ХУВИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ЭД ЗҮЙЛС БОЛОН АВТОМАШИНД ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТ ХИЙХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Зорчигчийн автомашин болон хувийн хэрэглээний эд зүйлсэд гаалийн бүрдүүлэлт хийх, зорчигчоос албан татваргүй нэвтрүүлэх хувийн хэрэглээний эд зүйлсийн тоо хэмжээ, үнийн дүнг тогтооход энэхүү журмыг баримтлана.

1.2 Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлсийн үнийн дүн, тоо хэмжээг нь түүний аяллын зорилго, нөхцөл байдал, хэдэн удаа улсын хилээр нэвтэрсэн зэргийг харгалзан биедээ авч яваа болон биеэс тусдаа илгээсэн ачаа тээш нь арилжааны шинж чанаргүй болох нь илэрхий байх зэргийг үндэслэн тогтооно.

Мөн зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлсэд очих газар хүртэл хүрэлцэх, дахин боловсруулалт шаардагдахгүй хүнсний бараа хамаарна.

1.3 Зорчигчийн гар тээш болон аялж буй тухайн тээврийн хэрэгслийн ачаа, тээшин дэх барааг - дагалдах ачаанд харин өөр тээврийн хэрэгсэл болон чингэлгээр зорчигчоос ирүүлсэн /явуулсан/ барааг биеэс тусдаа ачаанд хамааруулан тус тус тооцно.

Хоёр. Зорчигчийн гаалийн мэдүүлэг

2.1 Зорчигчийн биедээ авч яваа хувийн хэрэглээний эд зүйлс болон биеэс тусдаа явуулсан бараанд гаалийн бүрдүүлэлт хийх үндэслэл нь гаалийн мэдүүлэг болно.

2.2 Хилийн гаалийн байгууллага нь биеэс тусдаа бараатай зорчигчдод гаалийн мэдүүлгийг 2 хувь бичүүлж, 1-р хувийг хилийн гаалийн байгууллага авч, 2-р хувийг гаалийн бүрдүүлэлт хийлгэх гаалийн байгууллагад хүргүүлэхээр эзэнд нь өгнө.

2.3 16 нас хүрээгүй зорчигчийн барааг эцэг эхийн, эсхүл асран хамгаалагчийн гаалийн мэдүүлэгт хамт бичнэ.

2.4 Дамжин өнгөрөх зорчигчийн гаалийн мэдүүлэгт тэмдэглэсэн бараа нь монгол улсад ороод гарах хүртлэх хугацаанд гаалийн хяналтанд байна.

2.5 Хилийн гаалийн байгууллагын гаалийн улсын байцаагч гаалийн мэдүүлэгт хувийн тэмдгээ тод дарж, өөрийн нэр, гарын үсгээ гаргацтай зурснаар гаалийн мэдүүлэг хүчин төгөлдөр болно.

Гаалийн мэдүүлэггүй буюу хүчин төгөлдөр бус гаалийн мэдүүлэгтэй тохиолдолд журмын "Гурав"-ын 3.1-д заасан нөхцлүүд тухайн зорчигчдод хамаарахгүй болно.

2.6 Зорчигч гаалийн мэдүүлэггүй буюу хүчин төгөлдөр бус гаалийн мэдүүлэгтэй байснаас гаалийн бүрдүүлэлт хийхэд гарсан зардлыг буруутай этгээд хариуцах болно.

Гурав. Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлс

3.1 16- аас дээш насны зорчигчийн татваргүй нэвтрүүлэх хувийн хэрэглээний эд зүйлсийн тоо хэмжээ, үнийн дүн:

3.1.1 18-аас дээш насны зорчигчид архи 1 литр, дарс 2 литр, пиво 3 литр, янжуур 200 ширхэг, сигар, навчин тамхи 50 ширхэг, задгай тамхи 250 граммаас илүүгүй.

3.1.2 Зорчигчийн гар тээш, дагалдах болон биеэс тусдаа явуулсан ачаанд улсын хилээр нэвтрүүлэх арилжааны шинж чанаргүй барааг:

а/ гаалийн хилээр ороход 1000. ам. долл. хэмжээнд

б/ гаалийн хилээр гарахад 500 ам. долл. хэмжээнд

3.1.3 Улсын хилээр байнга нэвтрэх тээврийн хэрэгслийн бие бүрэлдхүүн, төмөр замын агент биедээ авч яваа дараах үнэ бүхий бараа:

а/ гаалийн хилээр ороход 50. ам. долл. хэмжээнд

б/ гаалийн хилээр гарахад 30 ам. долл. хэмжээнд

3.1.4. Монгол Улсад буюу гадаадад 6 сараас дээш хугацаагаар шилжин суурьшиж буй иргэдийн хэрэглэж байсан хувийн эд хогшил, гэр ахуйн эдлэл зохих нэгжээр:

3.1.5. Монгол Улсын болон олон улсын хууль тогтоомжинд зааснаар татвараас чөлөөлөгдөх зорчигчийн автомашин.

3.1.6. Зорчигчийн аяллын зорилго, хугацаа, жилд хэдэн удаа улсын хилээр нэвтэрсэн зэргийг харгалзан компьютер, гар утас, гэр ахуйн цахилгаан бараа, гэрэл зургийн буюу кино, дүрс бичлэгийн аппарат, бичгийн машин, хөгжмийн зэмсэг зэрэг техник хэрэгсэл тус бүр 1 ширхэг.

3.1.7 Зорчигч өөрийнхөө хэрэгцээнд зориулан авч яваа нэг курс эмчилгээнд хүрэлцэхгүй эм, биобэлдмэлийн тун.

3.1.8. Нотариатын, эсхүл засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн баталгаажуулсан гэрчилгээнд заасан нэр төрөл, тоо хэмжээ бүхий өв залгамжлалын эд хөрөнгө /өв залгамжлалын эд юмс, үнэт эдлэлийг борлуулсан орлогоор худалдан авсан зүйлийг өв залгамжлалын эд хөрөнгөд үл тооцно./

Дөрөв. Зорчигчийн автомашинд гаалийн бүрдүүлэгт хийх.

4.1 Гаалийн байгууллага нь 3.1.5-д хамаарахгүй "бараа" гэж үзэх тохиолдолд/ зорчигчийн автомашины /цаашид " автомашин" гэх/ гаалийн бүрдүүлэлтийг барааны гаалийн мэдүүлгийн үндсэн дээр хийж, холбогдох татаар, хураамжийг бүрэн барагдуулна. Хөлөөрөө орж ирсэн автомашины гаалийн бүрдүүлэлтийг хилийн гаалийн байгууллага хийж дуусгана. Бүрдүүлэлт хийсэн гаалийн улсын байцаагч техникийн паспорт /үйлдвэрийн дагалдах/ дээр гаалийн хяналтын "Эзэнд нь ологхыг зөвшөөрөв" тэмдгийг хувийн тэмдгийн хамт дарна.

4.2 Бараа эзэмшигч нь автомашины техникийн паспорт /үйлдвэрийн дагалдах/, төлбөрийн баримт бичгийн эх хувь буюу баталгаажуулсан хуулбарыг гаалийн байгууллагад гаргаж өгнө.

4.3 Автомашины гаалийн бүрдүүлэлт хийхэд барааны гаалийн мэдүүлгийн 31 дүгээр хүснэгтэд автотээврийн хэрэгслийн техникийн паспорт, марк, арал/кузов/, хөдөлгүүрийн дугаар, өнгө, үйлдвэрлэсэн оныг тодорхой бичиж, гаалийн хяналтын тэмдэг болон гаалийн улсын байцаагчийн хувийн тэмдгийг техникийн паспорт /үйлдвэрийн дагалдах/ дээр дарна.

Тав.Бусад зүйл

5.1 Гуравдагч этгээдэд дамжуулах бараа,

эд зүйлсийг уг зорчигчийн бараа, эд зүйлсэд тооцож гаалийн бүрдүүлэлт хийнэ.

5.2 1000 ам. доллараас доош үнийн дүнтэй арилжааны шинж чанартай бараа болон 3.1.5-д заасан автомашинд "Зорчигчийн барааны гаалийн бүрдүүлэлтийн хуудас"-аар /Маягт-7/ гаалийн бүрдүүлэлт хийнэ.

Харин 3.1.5.-д зааснаас бусад автомашин болон гаалийн хилээр гарахад - 500 ам. долл, ороход -1000 ам. доллараас дээш үнийн дүнтэй бараанд "Барааны гаалийн мэдүүлэг"-ээр /Маягт - ГМ1/ гаалийн бүрдүүлэлт тус тус хийнэ.

5.3 Хуваагдахгүй эд зүйлсэд тооцогддог /журмын "Гурав"-ын 3.1-д заасан бараа үүнд хамаарахгүй/ зохих нэгжээр 1000 ам. доллараас дээш үнийн дүнтэй бараанд зохих татварыг холбогдох хууль тогтоомжийн дагуу ногдуулж барагдуулна.

5.4 . Журмын 3.1.7-д зааснаас бусад эм, эмийн түүхий эд, түүнчлэн боловсруулаагүй, эсхүл дахин боловсруулалт хийгдэх мал, амьтан, ургамлын гаралтай түүхий эд, материалыг зорчигчийн журмаар гаалийн хил нэвтрүүлэхийг зөвшөөрөхгүй. Ардын эмнэлгийн монгол эм, танг холбогдох байгууллагын тодорхойлолт, гэрчилгээг үндэслэн улсын хил нэвтрүүлнэ.

5.5 Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн валютыг гаалийн байгууллагад мэдүүлсэн хэмжээгээр тус улсын гаалийн хилээр оруулж болно. Харин Монгол Улсын иргэн чөлөөтэй хөрвөдөг гадаадад валютыг холбогдох хууль тогтоомжоор хязгаар тогтоогоогүй бол гавьд мэдүүлсэн тоо, хэмжээгээр гадаадад гаргахыг зөвшөөрнө. Гадаадын иргэд, харьяалалгүй хүмүүсийн авч яваа валютыг гаалийн мэдүүлэг, төлбөр тооцооны бичиг баримтыг үндэслэн улсын хилээр гаргана.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргал.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12
Төрийн ордон

■ 329612
Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэлтэх үйлдвэрт хэлтэн.

■ 329487